

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2018.07.24-2018.08.21/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ИТХ-ын 13-р хурал 2018 оны 08-р сарын 14-нд зохион байгуулагдаж эхний хагас жилийн “Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл”-ийн тайлан, “Зорилтот өрх”-ийн тайлан, ХАБЭАОТБЗөвлөлийн тайлан, хамтарсан багийн тайлангуудыг тус тус хэлэлцэж хангалттай гэж үнэллээ.

Засаг даргын 2018 оны А/74 тоот захирамжаар “Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах” ажлын хэсэг томилогдон малчдын өвөлжилт, хаваржилтын бэлтгэлтэй танилцан 18 малчин айл өрхөөр явж санал сэтгэгдлийг сонсож сумын Засаг даргын албан даалгавар, өвөл хэрэглэгдэх өвс тэжээлийн нормын тооцоо, судалгааг тараан өгч ажиллалаа.



"Шивээ Овоо" Хувьцаат компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд 2018-2019 оны хичээлийн шинэ жилийг тохиолдуулан зорилтод бүлгийн 26 хүүхдэд сурагчийн дүрэмт хувцас, хичээлийн хэрэглэл, гарын бэлэг гардууллаа.





ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

2018 оны 08-р сарын 21-ний өдрийн байдлаар орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл өссөн дүнгээр дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	ИТХ	28434000	27251887
2.	ЗДТГ	189135600	187812374

Төвлөрсөн төсөвт байгууллагуудын зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /төгрөгөөр/	Зардлын гүйцэтгэл /төгрөгөөр/
1.	Эрүүл мэндийн төв	212112500	208757008
2.	Соёлын төв	39272500	35903478
3.	3-р сургууль	457154500	455758800
4.	3-р цэцэрлэг	247193800	244661659

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

- Эмнэлэгт хэвтсэн-27 үүнээс хүүхэд-7, дотор-20
- Амбулаторийн үзлэг-309
- Дуудлага-77

Элэгний В, С вирустай тэмцэх өдрийн хүрээнд 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр Шивээговь сумын төв талбайд иргэдэд үйлчлэн өндөр, жин, даралт, В, С вирусын шинжилгээ, хөхний үзлэг болон цусан дахь сахарын хэмжээ зэргийг тодорхойлон элэгний В, С вирусын талаар зөвлөгөө мэдээлэл өгч 8 төрлийн гарын авлага тараан ажиллалаа.

В, С вирусын илрүүлгийн шинжилгээнд 15-39 насны 20 иргэн хамрагдаж, элэгний В вирустэй 1 иргэнийг дараагийн шатлалын шинжилгээнд хамруулсан.

Хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт зорилтод бүлгийн (20-60 насны) 18 эмэгтэйг, чихрийн шижин хэв шинжийн үзлэгт 8 иргэнийг тус тус хамруулсан.



2018 оны 07 сарын 25-27-ны өдөр тарваган тахлын дархлаажуулалтын вакцин хийж 62 иргэнийг хамрууллаа.

Тарваган тахлын вакцинд хамрагдсан байдал:

Хамрагдсан иргэд	Иргэдийн тоо
Малчид	17
Оюутан сурагчид	4
Бусад	9
6 сар-6 нас	0
7-10 нас	0
11-14 нас	0
15-18 нас	2
19-45 нас	47
46-60 нас	13
60-дээш нас	0
Дүн	62

Сумын Засаг даргын 2018 оны А/85 дугаар захирамжийн дагуу Эрүүл мэндийн төвийн 4 эмч, ажилтан Хаялга орчмоор эргүүл хийж, амарч байсан 18 том хүн, 6 хүүхдэд зөвлөгөө өгч ажиллалаа.



Байгалийн гамшигт үерийн улмаас төмөр замд эвдрэл үүсч воган осолдсон дуудлагын дагуу 8-р сарын 12-ны өдөр 3 их эмч, 2 сувилагч Говьсүмбэр аймгийн нэгдсэн эмнэлэг дээр иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэж ажиллалаа.



Мөн өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу бүх өрөөний цонхны дулаалгыг бүрэн хийж сантехникийн уян зөөлөн холбоос, холигч, хуучин эмнэлгийн сантехникийн уян зөөлөн холбоосыг сольж, яаралтай тусламж үйлчилгээний автомашинд 4ш дугуй, олгой солих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

СОЁЛЫН ТӨВ:

“Нүүдэлчин монгол-2018” соёлын биет бус өвийн их наадамд сумаас 5 иргэн оролцосноос сумын ардын авьяастан Б.Батсайхан, Д.Төрболд нар “Тэргүүний ардын авьяастан” цол тэмдэгээр шагнагдлаа.



ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ

Ахмад настаны тухай хуулийн дагуу ахмадын зориулалттай амралт сувилалд 14 ахмад настанг амруулж 2,8 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн.

“Энх-Оюу дэмжих” хүнсний дэлгүүрээс 7,8 дугаар сард “Хүнсний эрхийн бичиг”-ийн үйлчилгээнд хамрагдсан 12 өрхийн 74 гишүүнд 1,824,000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн олгосон.



БАЙГАЛЬ ОРЧИН

Нийтийг хамарсан ажилд ажилгүй 5 иргэнийг түр ажлын байраар ханган сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайн хогийг цэвэрлэх, наадмын талбайн элс, хог хаягдлыг цэвэрлэх ажилд 10 хоног ажиллуулж нийт 46,2м³ хог хаягдлыг түүж цэвэрлүүлэн төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан.


Бүх нийтийн их цэвэрлэгээг хуваарийн дагуу зохион байгуулж 32 иргэн 9м³ хог хаягдлыг цэвэрлэж төвлөрсөн хогийн цэгт зайлуулаа. Мөн сумын төвд үхсэн нэг нохойн сэгийг ариутгаж төвлөрсөн хогийн цэгт булж устгалаа.



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Сумын төвийн гудамж, талбай, албан байгууллага, айл өрхийг үе шаттайгаар хаягжуулах ажлыг “Их эффект” ХХК-тай 4,8сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж гүйцэтгүүлж улсын комисс ажиллуулах шатандаа байна. Үүнд: байшин барилга-54 ширхэг, Орцны хаяг-53, объектын байрлыг заасан тэмдэг-1 ширхэгийг тус тус байршуулж суурилуулсан.





3 дугаар сургуулийн цахилгааны монтажыг хэсэгчлэн шинэчлэх ажлын гүйцэтгэгчээр “Энхжих формат”ХХК-ийг шалгаруулан 19,877,879 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан. Ажлын явцад хяналтын комисс ажиллуулан үүрэг даалгавар өгч ажиллаж байна.



“3-р Цэцэрлэгийн гэр цэцэрлэгийг тохижуулах/ гэр, зөөлөн эдлэл/” ажлыг “ОЧХИЙЦ”ХХК-тай 5,8 сая төгрөгөөр нийлүүлэхээр гэрээ байгуулж барааг хүлээн авлаа.Үүнд: 6 ханатай иж бүрэн гэр, 30 хүүхдийн хөнжил, гудас, ор хөнжлийн даавуу зэрэг болно.





ТАЙЛАН ГАРГАСАН: ДАХОХААХМ С. БАНЗРАГЧ